

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/023/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

СМД аудит ХХК-ийн Аудитын менежер: Б.Мөнхцацрал
Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn

Аудитор: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.12

№

40

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 60,527.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилт 4,732.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвөөс 2,601.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, хандив тусламжаар ирсэн 8,730.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй 5,268.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг тус тус хүлээн аван данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудал

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 1 хөтөлбөр, 5 зорилт, 73 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 98.0 хувиар үнэлж хүргүүлсэн бөгөөд аймгийн Боловсролын газраас 87.0 хувиар "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

ЭРДЭНЭ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ОТГОНБАЯР ТАНАА

822505000104

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,414,581.95	76,611,765.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	78,325,415.15	19,607,143.62
312	Банканд байгаа бэлэн мөнгө	78,325,415.15	19,607,143.62
3121	Төгрөг	78,325,415.15	19,607,143.62
31211	Төрийн сангийн харилцах	78,325,415.15	19,607,143.62
33	АВЛАГА	0.00	781,193.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	781,193.05
34	УРЬДЧИЛГАА	0.00	300,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	0.00	300,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	0.00	300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	55,089,166.80	55,923,428.80
351	Түүхий эд материал	36,010,682.80	31,236,754.80
35110	Тусгай зориулалттай материал	35,490,682.80	31,236,754.80
35130	Эм боох материал	520,000.00	0.00
354	Хангамжийн материал	19,078,484.00	24,686,674.00
35410	Бичиг хэргийн материал	548,100.00	0.00
35420	Аж ахуйн материал	7,811,350.00	7,971,350.00
35460	Хүнсний материал	2,582,050.00	8,578,340.00
35470	Бусад хангамжийн материал	8,136,984.00	8,136,984.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	883,212,863.52	862,242,945.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	883,212,863.52	862,242,945.33
392	Биет хөрөнгө	877,988,863.52	851,780,945.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	996,408,886.66	996,408,886.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-155,610,863.08	-180,702,124.15
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,867,240.00	59,597,240.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,329,500.39	-44,337,661.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,707,970.59	55,308,970.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,880,770.26	-35,296,266.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,063,233.00	13,063,233.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,945,233.00	-12,969,233.00
39217	Ном	707,900.00	707,900.00
393	Биет бус хөрөнгө	5,224,000.00	10,462,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,224,000.00	10,462,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,016,627,445.47	938,854,710.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,016,627,445.47	938,854,710.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,016,627,445.47	938,854,710.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	30,734,240.00	30,734,240.00
51101	Өмч: - төрийн	30,734,240.00	30,734,240.00
512	Хуримтлагдсан үр дүн	922,970,643.50	845,197,908.83
51210	Өмнөх үеийн үр дүн	935,057,472.66	922,970,643.50
51220	Тайлант үеийн үр дүн	-12,086,829.16	-77,772,734.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,922,561.97	62,922,561.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,016,627,445.47	938,854,710.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	599,687,700.00	666,945,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,145,000.00	15,143,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,145,000.00	15,143,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,070,000.00	13,968,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,040,000.00	1,070,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	586,542,700.00	651,802,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	522,406,400.00	582,933,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	522,406,400.00	582,933,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,136,300.00	68,869,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,136,300.00	68,869,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	611,774,529.16	744,718,634.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	611,774,529.16	744,718,634.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	609,261,547.97	743,061,234.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,976,535.25	518,498,969.89
210101	Үндсэн цалин	275,104,254.93	329,773,732.59
210102	Нэмэгдэл	120,982,803.39	175,580,555.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,540,000.00
210104	Урамшуулал	13,889,476.93	11,604,681.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,183,800.00	58,584,906.95
210201	Тэтгэврийн даатгал	34,805,300.00	39,840,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,094,700.00	4,687,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,047,200.00	2,343,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,047,200.00	2,343,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,189,400.00	9,370,806.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,224,318.81	47,865,254.27
210301	Гэрэл, цахилгаан	6,115,098.81	6,018,421.64
210302	Түлш, халаалт	35,531,360.00	39,232,640.00
210303	Цэвэр, бохир ус	6,577,860.00	2,614,192.63
2104	Хангамж, бараа материалын зардал	-	17,605,118.00
210401	Бичиг хэрэг	-	3,837,450.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,134,640.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,315,100.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,317,928.00
2105	Нормативт зардал	32,027,020.00	36,820,860.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	527,500.00
210502	Хоол, хүнс	32,027,020.00	36,293,360.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,399,000.00	-
210604	Урсгал засвар	13,399,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	853,900.00	2,175,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853,900.00	2,175,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,596,973.91	61,510,525.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,581,250.00	20,998,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,061,850.00	2,973,007.37
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,953,873.91	37,538,918.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,512,981.19	1,657,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,512,981.19	1,657,400.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,512,981.19	1,657,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(12,086,829.16)	(77,772,734.67)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,086,829.16)	(77,772,734.67)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>586,577,700.00</u>	<u>651,907,900.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	586,542,700.00	651,802,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	522,406,400.00	582,933,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	522,406,400.00	582,933,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,136,300.00	68,869,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,136,300.00	68,869,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>571,238,915.25</u>	<u>708,016,171.53</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,238,915.25	708,016,171.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	568,725,934.06	706,358,771.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,976,535.25	518,798,969.89
210101	Үндсэн цалин	275,104,254.93	330,073,732.59
210102	Нэмэгдэл	120,982,803.39	175,580,555.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	1,540,000.00
210104	Урамшуулал	13,889,476.93	11,604,681.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,183,800.00	59,366,100.00
210201	Тэтгэврийн даатгал	34,805,300.00	40,373,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,094,700.00	4,750,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,047,200.00	2,376,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,047,200.00	2,376,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,189,400.00	9,491,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,224,318.81	49,029,200.00
210301	Гэрэл, цахилгаан	6,115,098.81	6,018,421.64
210302	Түлш, халаалт	35,531,360.00	39,232,640.00
210303	Цэвэр, бохир ус	6,577,860.00	3,778,138.36
2105	Нормативт зардал	28,988,380.00	42,322,250.00
210502	Хоол, хүнс	28,988,380.00	42,322,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,399,000.00	18,182,600.00
210604	Урсгал засвар	13,399,000.00	18,182,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	853,900.00	2,340,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853,900.00	2,340,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,100,000.00	16,319,051.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,038,150.00	12,291,301.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,061,850.00	4,027,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,512,981.19	1,657,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,512,981.19	1,657,400.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,512,981.19	1,657,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>15338784.75</u>	<u>-56108271.53</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,800,000.00	2,610,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,800,000.00	2,610,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,800,000.00	2,610,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,800,000.00	2,610,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,800,000.00</u>	<u>-2,610,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,538,784.75	-58,718,271.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,786,630.40	78,325,415.15
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,325,415.15	19,607,143.62

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	30,734,240.00	62,922,561.97	935,057,472.66	1,028,714,274.63
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,734,240.00	62,922,561.97	935,057,472.66	1,028,714,274.63
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-12,086,829.16	-12,086,829.16
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,734,240.00	62,922,561.97	922,970,643.50	1,016,627,445.47
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	30,734,240.00	62,922,561.97	922,970,643.50	1,016,627,445.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,734,240.00	62,922,561.97	922,970,643.50	1,016,627,445.47
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-77,772,734.67	(77,772,734.67)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,734,240.00	62,922,561.97	845,197,908.83	938,854,710.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	720,387,300.00	708,968,771.53	11,418,528.47	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	720,387,300.00	708,968,771.53	11,418,528.47	98.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	720,387,300.00	708,968,771.53	11,418,528.47	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	521,892,200.00	518,798,969.89	3,093,230.11	99.4
210101	Үндсэн цалин	330,670,400.00	330,073,732.59	596,667.41	99.8
210102	Нэмэгдэл	183,606,300.00	175,580,555.75	8,025,744.25	95.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,540,000.00	(1,540,000.00)	-
210104	Урамшуулал	7,615,500.00	11,604,681.55	(3,989,181.55)	152.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,941,100.00	59,366,100.00	5,575,000.00	91.4
210201	Тэтгэврийн даатгал	44,047,500.00	40,373,000.00	3,674,500.00	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,223,500.00	4,750,100.00	473,400.00	90.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,611,700.00	2,376,000.00	235,700.00	91.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,611,700.00	2,376,000.00	235,700.00	91.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,446,700.00	9,491,000.00	955,700.00	90.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,029,200.00	49,029,200.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	6,880,000.00	6,018,421.64	861,578.36	87.5
210302	Түлш, халаалт	37,049,200.00	39,232,640.00	(2,183,440.00)	105.9
210303	Цэвэр, бохир ус	5,100,000.00	3,778,138.36	1,321,861.64	74.1
2105	Нормативт зардал	43,199,400.00	42,322,250.00	877,150.00	98.0
210502	Хоол, хүнс	43,199,400.00	42,322,250.00	877,150.00	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,840,000.00	18,182,600.00	1,657,400.00	91.6
210604	Урсгал засвар	19,840,000.00	18,182,600.00	1,657,400.00	91.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,395,100.00	2,340,600.00	54,500.00	97.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,395,100.00	2,340,600.00	54,500.00	97.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,090,300.00	18,929,051.64	161,248.36	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,991,900.00	14,901,301.64	90,598.36	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,098,400.00	4,027,750.00	70,650.00	98.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	720,387,300.00	650,250,500.00	70,136,800.00	90.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	651,518,100.00	582,933,700.00	68,584,400.00	89.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	651,518,100.00	582,933,700.00	68,584,400.00	89.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,869,200.00	67,211,800.00	1,657,400.00	97.6
132001	Орон нутгийн төсвөөс	68,869,200.00	67,211,800.00	1,657,400.00	97.6

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	105,000.00	(105,000.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		105,000.00	(105,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,325,415.15	(78,325,415.15)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,607,143.62	(19,607,143.62)	-

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 9,232.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 4 алдаа¹-г аудитын явцад залруулж, тайлагнасныг баталгаажуулав.

Залруулсан алдаа:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Нийгмийн даатгалын хэлтэст төлөх шимтгэлийн авлага 781,2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.
- Эмийн зарцуулалтын 1 дүгээр сард шаардах хуудсаар гарсан нярвын тайлангийн 520.0 мянган төгрөгийн зарлагыг тайланд нягтлан бодогч хасалт хийгээгүй.
- Эрхлэгчийн 2025 оны 12 дугаар сарын 01-ний А/13 тушаалын дагуу 5,384.8 мянган төгрөгийн акталсан бараа материалыг зарцуулснаар тайлагнасан.
- Удмын түшиг ХХК-аас 2025 оны 11 дүгээр сарын 20-ны нэхэмжлэхээр 2,546.2 мянган төгрөгийн махыг хүнсний материалын тайланд 11, 12 дугаар саруудад давхардуулан мөнгө шилжээгүй байхад санхүүгийн программд орлого авч жилийн эцэст нярвын үлдэгдлээс илүү тайлагнаж, орлого авсан өглөгийг шууд зардлаар тохируулан бичсэн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж бүртгэсэн.

Залруулагдаагүй 8,951.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар санхүүгийн аудиттай холбоотой нийт 8,951.6 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 300.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8,651.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

1. Ажиллагсдад олгосон 11 дүгээр сарын урьдчилгаа цалингаас Д.Алтанцэцэгийн 300.0 мянган төгрөгийг дутуу суутгаж, авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-г "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан 300.0 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Зөвлөмж

1. Бүртгэл тайлагнал, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрхлэгчийн 2025 оны А/12 дугаар тушаалын дагуу томилогдсон тооллогын комиссын тооллогын дүнг өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцэж тооллогын дүнг тушаалаар батлаагүй, нягтлан бодогч тооцоог бодож баталгаажуулаагүй, нягтлан бодогч бараа материалын тайлангийн орлого, зарлагыг сар бүр няравтай тооцоо нийлж тулгаж баталгаажуулдаггүйгээс 2,546.2 мянган төгрөгөөр илүү орлого авч нярвын үлдэгдэл зөрүүтэй байхад тооцоо бодоогүй, дахин нягтлаагүй тайлан гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид хууль, тогтоомжийг хэрэгжүүлж хөрөнгийн тооллогын дүнг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн, баталгаажуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн эрхлэгчийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Б/04 дүгээр тушаал гаргаж, тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 16,955.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хүрээнд албан хаагчдад олгох хоол, унааны хөнгөлөлтийг төсөвт тусгуулан, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж		
								Запуулсан		Запуулаагүй				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
Эрдэнэ сумын цэцэрлэг	Нийгмийн даатгалын хэлтэст төлөх шимтгэлийн авлага 781,2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	781.2	1	781.2			1	781.2	-	-	-	-	
	Эмийн зарцуулалтын 1-р сард шаардах хуудсаар гарсан нярвын тайлангийн 520.0 мянган төгрөгийн зарлагыг тайланд нягтлан бодогч хасалт хийгээгүй.	1	520.0	1	520.0			1	520.0					
	Эрхлэгчийн тушаалын дагуу 5,384.8 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байхад зарцуулснаар тайлагнасан.	1	5,384.8				1	5,384.8	1	5,384.8				
	Удмын түшиг ХХК-наас нэхэмжлэхээр 2,546.3 мянган төгрөгийн махыг давхардуулан санхүүгийн программд орлого авч, өглөгийг шууд зардлаар тохируулан бичсэн	1	2,546.3				1	2,546.3	1	2,546.3				
Дүн		4	9,232.2	2	1,301.2	2	7,931.0	4	9,232.2		-	-	-	

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг	Ажиллагсдад олгосон 11 сарын урьдчилгаа цалингаас Д.Алтанцэцэгийн 300.0 мянган төгрөгийг дутуу суутгаж, авлагаар бүртгээгүй.	1	300.0	1	300.0	-	-	-	-	-	-	
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн эрхлэгчийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Б/04 дугаар тушаал гаргаж, тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 16,955.0 мянган төгрөгийг олгосон	1	-						1	-		
	Эрхлэгчийн 2025 оны А/12 дугаар тушаалын дагуу томилогдсон тооллогын комиссын тооллогын дүнг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж тооллогын дүнг тушаалаар батлаагүй, нягтлан бодогч тооцоог бодож баталгаажуулаагүй, нягтлан бодогч хүнсний тайлангийн орлого, зарлагыг сар бүр няравтай тооцоо нийлж тулгаж баталгаажуулдаггүйгээс 2,546.2 мянган төгрөгөөр илүү орлого авч нярвын үлдэгдэл 8,651.6 мянган төгрөг байхад дахин нягтлаагүй тайлан гаргасан.	1	8,651.6						1	8,651.6		
Дүн		3	8,951.6	1	300.0	-	-	2	8651.6	-	-	

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 789,267,970 мянган төгрөгийн 156 мэдээлэл оруулахаас 502,011.6 мянган төгрөгийн орлогын 25 гүйлгээ, 25,337.1 мянган төгрөгийн зарлагын 7 гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой 7,500.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, 43,530.0 мянган төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	43,530.0	-	-	-	-	1	43,530.0	-	-
Дүн		3	52,481.6	1	300.0	-	-	2	52,181.6	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			